

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ,
ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ АЖИЛТНУУД,
ХАМТАРСАН БАГУУДЫН ЗҮГЭЭС

КОВИД-19

ЦАР ТАХЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ





НҮБ-ын Хүн Амын Сан

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ, ТҮР ХАМГААЛАХ БАЙРНЫ АЖИЛТНУУД, ХАМТАРСАН БАГУУДЫН ЗҮГЭЭС КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

[2021 оны 4-р сард шинэчлэв]

А. КОВИД-19 БОЛОН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Онцгой байдал, хямрал, олон нийтийг хамарсан өвчлөлийн үед жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ), мөлжлөг дарангуйлал, дарамт ихэсдэг нь олон улсын туршлагаар нотлогдсон байдаг. Бүх нийтийн хөл хорио тогтоосон болон тусгаарлалт зэрэг цар тахлын эсрэг арга хэмжээнүүд нь хүчирхийлэлд өртөх эрсдэлийг улам бүр ихэсгэдэг. Хүмүүсийн дунд стресс бухимдал ихсэж, хөрөнгө нөөц, хөл хөдөлгөөн нь хязгаарлагдаж, хүчирхийлэгчийн хараа хяналтанд орох, нийгмийн дэмжлэг болон үйлчилгээнээс алслагдах зэрэг олон асуудлууд үүсдэг нь жендэрийн тэгш бус байдал нэмэгдэж, ЖСХ нэмэгдэхэд нөлөөлдөг. Дэлхий дахинаа Ковид-19 цар тахал тархаснаас хойш ЖСХ, ялангуяа гэр бүлийн хүчирхийллийн (ГБХ) мэдээлэгдсэн тохиолдлуудын тоо эрс өсч, Монголд ч мөн энэ үзэгдэл ажиглагдаж байна.

ЖСХ, тэр дундаа ГБХ болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн гаралт цар тахлын үед огцом өссөн. 2020 онд ГБХ-ийн тохиолдол 15%-иар өссөн нь урьд жилүүдтэй харьцуулахад бага хувиар өссөн үзүүлэлт боловч Монгол улсад сүүлийн жилүүдэд тогтвортой буурах хандлагатай байсан ГБХ-ийн ноцтой хэргүүдийн хувь 16%-иар ихэссэн байна.

Хүүхдүүд бас хүчирхийлэлд өртөх явдал эрс нэмэгдлээ. Сургуулиудыг хааж, хөл хорио тогтоосон үед хүүхдүүд, өсвөр үеийнхэн уйдаж, ганцаардан, уурлаж, улмаар эцэг эхийнхээ санаанд нийцэхгүй зүйл хийж, эцэг эх, хүүхдийн хоорондын зөрчил нь даамжирсаар сэтгэл санаа, бие махбодын хүчирхийлэл гарахад хүрч байна.

Энэ удирдамж нь хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), түр хамгаалах байрны (ТХБ) ажилтнуудын зүгээс цар тахлын үед жендэрт суурилсан хүчирхийлэлд зохих хариу арга хэмжээ авч, үйлчлүүлэгчдээ хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой мэдээлэл бүхий удирдамж бөгөөд үйлчилгээ үзүүлэхэд мөрдөж буй өнөөгийн хүчин төгөлдөр удирдамж, дүрэм журамд нэмэлт хавсралтаар хэрэгжүүлнэ.

Б. ЯАРАЛТАЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА¹

1. Үйлчилгээний бүх цэгүүдэд стандартын дагуу халдвараас урьдчилан сэргийлэх, хяналтын арга хэмжээг нэн даруй авах.

- а. Үйлчлүүлэгчтэй уулзах газруудад гар угаах угаалтуур суурилуулах, эсвэл үүдэнд гар ариутгагч байршуулах.
- б. Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аль аль нь байнга амны хаалт/маск/зүүх эсвэл бусад шаардлагатай хувь хүний хамгаалах хэрэгслийг хэрэглэх ба

хувь хүний хамгаалах хэрэгслийг заасан хугацаанд нь хэрэглэсний дараа шинээр сольж байх.

- в.** Үйлчлүүлж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдийг 1-2 метрийн зайтай байлгах, олон хүн нэг дор цуглуулахгүй байх. Нэг дор үйлчилгээ авах үйлчлүүлэгчдийн тоонд хязгаар тогтоох, өрөөний зохион байгуулалтыг өөрчлөх (сандлуудыг хооронд нь зайтай байрлуулж, тэмдэг тавих гэх мэт).
- г.** Халдвараас урьдчилан сэргийлэх, хяналтын арга хэмжээ авах боломжгүй, хүмүүсээс зай барих боломжгүй хүн ихтэй газруудруу кейс ажилтныг явуулахгүй байх.
- д.** Бүх ажилтнуудыг гараа угаах боломжтой нөхцөл, гар ариутгагч, хувь хүний хамгаалах хэрэгслээр хангаж, тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх хэрэгсэл, гар утас, гар утасны нэгжээр хангах.

2. Ковид-19 цар тахлаас үүдэн үйлчилгээнд гарах өөрчлөлтүүдийг охид, эмэгтэйчүүдэд ил тод танилцуулж, тайлбарлах.

- а.** Үйлчилгээ үзүүлэх арга хэлбэр өөрчлөгдсөн ч, үйлчлүүлэгчдийг ганцааранг нь орхилгүй, тэднийг дэмжин, үйлчилгээ үзүүлсээр байх болно гэдгийг тайлбарлах. Тэдний айдас түгшүүр, асуулт, зөвлөгөө, бусад санаа зовоосон зүйлсийг анхааралтай сонсох.
- б.** Шинээр гарч буй мэдээлэл, удирдамжид нийцүүлэн Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн сацуу үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах.
- в.** Зөвлөгөө өгөх утасны дугаар, үйлчилгээнд гарсан өөрчлөлт, тухайн өөрчлөлтийн хүрээнд үйлчилгээ үзүүлэгчтэй хэрхэн холбогдох зэрэг мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд мэдээлэх.

3. Хөл хорионы улмаас ажилтнууд хамгаалах байрнаас гарч явах боломжгүй болсон тохиолдолд үйл ажиллагааг үргэлжлүүлэх зохицуулалт²

- а.** Хөл хорио тогтоосон үед НЦҮТ/ТХБ-ыг хариуцсан гол ажилтан үйлчилгээ, үйл ажиллагааг хянаж, НЦҮТ/ТХБ-нд боломжтой бол байрлаж, амьдарна. Бусад ажилтан гэртээ харьж, холбогдох үйлчилгээг зайнаас үзүүлж болно. Сайн дурын ажилтан, цагийн ажилтнууд нэг НЦҮТ/ТХБ-нд очиж болохгүй, үйлчилгээгээ зайнаас үзүүлнэ. Хөл хорионы үед НЦҮТ/ТХБ-нд өөр хүн (үйлчлүүлэгч бус) нэвтрүүлэхийг хориглоно.
- б.** Хөл хорионы үед НЦҮТ/ТХБ-нд амьдарч буй үйлчлүүлэгч, ажилтнууд гадагш гарахыг хориглоно. Хүнс, шаардлагатай эд зүйлсийг худалдан авах ажлыг нэг хүнд даалгаж, уг үүргийг хүлээсэн ажилтан л гадагш гарч явж болно. Уг ажилтан гадагш явж ирснийхээ дараа аливаа зүйлд хүрэхээсээ өмнө шууд гараа угааж, авч ирсэн зүйлсээ ариутгаж, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллана.
- в.** НЦҮТ/ТХБ-нд амьдарч буй үйлчлүүлэгчид Ковид-19 цар тахал ямар нэг шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тусгаарлах өрөөг сонгож, бэлтгэсэн байна. Үйлчлүүлэгчид шаардлагатай зүйлсийг уг өрөөнд тавихаас гадна цагаа

зугаатай өнгөрөөх зориулалттай нэмэлт зүйлсийг байрлуулна.

- г. НЦҮТ/ТХБ-нд байрлаж байгаа үйлчлүүлэгчдээс нэмж тусгаарлах шаардлага гарсан эсвэл багтаамж хэтэрсэн нөхцөлд орон нутгийн засаг захиргаатай хамтран нэмэлт өрөө, орыг бэлтгэнэ.
- д. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай холбогдон үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдийн ПСР шинжилгээ өгөх зохицуулалтыг хийх. Эрүүл мэндийн байгууллага нь шинжилгээний хариу ямар гарснаас шалтгаалан холбогдох байгууллагад холбон зуучлана.

4. Улс орны ковидын нөхцөл байдал өндөр эрсдэлтэй болсон үед НЦҮТ/ТХБ-ны ажилтнууд үйлчлүүлэхээр ирж байгаа хүмүүсийн хаагуур явсан, хэнтэй уулзсан болон ямар шинж тэмдгүүд илэрч мэдрэгдэж байгаа тухай лавлан асууж, маш тодорхой тэмдэглэл хөтлөх шаардлагатай. Ингэснээр халдвар илэрсэн тохиолдолд хавьтагчдыг илрүүлэх боломжтой болох юм.

В. “БҮРЭН ТУСГААРЛАЛТ”, “ХӨЛ ХОРИО” ЗЭРЭГ ГЭНЭТИЙН АРГА ХЭМЖЭЭНД БЭЛЭН БАЙХ³

2020 оны 11-р сард дотоодын халдвар анх бүртгэгдсэнээс хойш Монгол улсын Засгийн газар халдварын тархалтыг хумих зорилгоор хэсэгчилсэн хөл хорио, хатуу хөл хорио зэрэг төрөл бүрийн хязгаарлалтын арга хэмжээг авч ирлээ. Одоогоор өдөртөө дунджаар 800 гаруй тохиолдол бүртгэгдэж, нөхцөл байдал улам хүндэрч байна. Хурдацтай өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор эдгээр шийдвэрүүдийг богино хугацаанд гарган хэрэгжүүлж байна. Иймд, гарч болзошгүй нөхцөл байдлыг тооцож үйл ажиллагаагаа төлөвлөн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг тасалдуулахгүй, аюулгүй үзүүлэх арга замыг урьдчилан боловсруулан хэрэгжүүлэх нь чухал юм.

1. Бүрэн тусгаарлалт, хөл хорио эсвэл “байран дотроо тусгаарлах” хэрэг гарсан тохиолдолд ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлнэ. Дотоодод халдвар тархсан тохиолдолд тухайн орон нутгийн засаг захиргаанаас гаргасан хязгаарлалтын арга хэмжээнд тохируулан үйлчилгээ үзүүлэх арга барилаа өөрчлөх хэрэгцээ гарна. Эдгээр холбон зуучлах төлөвлөгөө нь үйлчилгээ үзүүлэгч болон тусламж эрсэн үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангахаас гадна нэн шаардлагатай, амь насыг аврах үйлчилгээг хүчирхийллийн хохирогчдод үргэлжлүүлэн тасалдуулахгүй хүргэхэд туслах юм.

а. Гол авч хэрэгжүүлэх арга хэмжээг судлах. Үүнд:

I. НЦҮТ/ТХБ-ууд үргэлжлүүлэн үйлчлүүлэгч авах уу?

II. Хэрэв **ТИЙМ** бол одоо байрлаж байгаа үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор зохицуулалтыг хийсэн байх ёстой. Жишээ нь: шинэ үйлчлүүлэгч ирэх үед ажилчид хувийн хамгаалах хэрэгсэл өмссөн байх, мөн Ковид-19 цар тахлын халдвар авсан хүнтэй ойр байсан эсэх, шинж тэмдэг илэрсэн эсэх талаар асуух. Боломжтой бол шинээр ирсэн үйлчлүүлэгчийг шинжилгээнд хамруулж, 14 хоног тусгаарлах.

III. Хэрэв **ҮГҮЙ** бол холбон зуучлах болон зайнаас тусламж үзүүлэх журмыг доорх хүчин зүйлсийг харгалзан боловсруулна. Үүнд:

1. Үйлчлүүлэгч хүчирхийлэл үйлдэгчээс тусдаа, аюулгүй байрлах өөрийн байртай эсэх?
2. Байргүй тохиолдолд, тэд гэртээ аюул, хохирлыг бууруулах ямар нэг арга хэмжээ авах боломжтой эсэх?
3. Нийгмийн ажилтан, утсаар зөвлөгөө өгдөг ажилтан, эсвэл өөр бусад дэмжлэгт үйлчилгээ үзүүлдэг ажилтнуудын утасны дугаарыг үйлчилүүлэгчид өгөх. Утастай бол, тэдний гар утсан дээр уг дугааруудыг өөр код нэрээр хадгалах, эсвэл амархан нууж болохуйц жижиг хуудсан дээр утасны дугааруудыг хэвлэж өгөх.
4. Тусламж хүсч утасдах, эсвэл тусламж авах өөр аюулгүй аргуудыг бодож болох.
5. Тусламж хэрэгтэй үед хөршдөө дохио өгөх арга хайж олж, төлөвлөх.

2. Үйлчилгээг зайнаас үзүүлэх шаардлагатай тохиолдолд (утсаар зөвлөгөө өгөх удирдамжийг “Зайнаас үзүүлэх үйлчилгээнд шилжих удирдамж”-аас авна уу) ажилтнууд уг нөхцөл байдалд хурдан дасан зохицох боломж олгох үүднээс ийм үед хүчирхийллийн шинэ тохиолдлыг шуурхай тодорхой шийдвэрлэх журмыг боловсруулах. Ингэхдээ дараах асуудал, арга хэмжээг судална. Үүнд:

- б.** Хүчирхийллийн тохиолдлыг шийдвэрлэхдээ ямар утас, утасны дугаарыг ашиглах вэ?
- в.** НЦҮТ-ийн ажилтнууд үйлчлүүлэгчидтэй хэр олон удаа холбогдож, харьцах вэ? Үйлчлүүлэгчид нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудтай хэрхэн холбогдох вэ?
- г.** Үйлчлүүлэгчид аюулгүй, ашиглах боломжтой утастай эсэх, мөн интернет холбогдсон эсэх? Түүнчлэн хохирогчид хүчирхийлэгчтэй утсаа дундаа хэрэглэдэг эсэхийг мөн анхаарах.
- д.** Үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлж байх үед нэмж болон шинээр үйлчлүүлэгч/дуудлага хүлээж авах боломжтой эсэх?
- е.** Дуудлагуудыг хэрхэн баримтжуулж, мөн холбогдох үйлчилгээг үзүүлэх арга хэмжээ авах вэ?
- ё.** Үйлчилгээг хүртээмжтэй байлгахын тулд ажилтнуудыг ээлжээр ажиллуулах уу?
- ж.** Энэ нь ажилтнуудын аюулгүй байдлыг хангах уу?
- з.** Ажиллагсдын аюулгүй байдлыг хангахын тулд ямар нэмэлт арга хэмжээг авах шаардлагатай вэ? Эдгээр арга хэмжээг авах боломжтой юу? Үгүй бол өөр ямар боломж байхыг тодруулах

3. Бичиг, баримтуудыг аюулгүй найдвартай цуглуулах, хадгалах⁴. Байгууллагууд хаагдсан тохиолдолд хэн нэгнийг эрсдэлд оруулалгүй, бичиг баримтуудыг аюулгүй найдвартай хадгалж, хамгаалах. Баримтуудыг цахим хэлбэрээр хадгалах, үйлчилгээг алсын зайнаас үзүүлэхийн тулд баримт нотолгоог гар утсан дээр хадгалах. Бичиг, баримтуудыг цаасан дээр хэвлэх болон цахим хэлбэрээр хадгалах журмыг боловсруулж, хэрэгжүүлэх.

Нийгмийн ажилтнууд болон дуудлагын утсан дээр ажиллах ажилчид зайнаас үйлчилгээ үзүүлэх тохиолдолд хэрхэн зохицож ажиллах талаар сургагдсан байх хэрэгтэй.

- a. Хэрэв зайнаас үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тоо мэдээлэл, баримт бичгийг хэрхэн хадгалах талаархи зөвлөмжүүд:
 - i. Нийгмийн ажилтан болон бусад холбогдох ажилтнууд тоо мэдээлэл, баримт нотолгоог хадгалан хамгаалах гэрээнд гарын үсэг зурсан байх.
 - ii. ЖСХ-ийн кейсийн болон бусад баримтуудын эх хувь нийгмийн ажилтан, түүний удирдах ажилтны гэрт гэх зэрэг хэн нэгэн зөвшөөрөлгүйгээр хүрч болох ямар ч газар байх ёсгүй.
 - iii. Хэн нэгэн зөвшөөрөлгүй олж авах боломжтой тул зайнаас үйлчилгээ үзүүлж байхдаа нийгмийн ажилтан гараар тэмдэглэл хөтлөхгүй байх.
 - 1. Үйлчлүүлэгчийн холбогдох дугаар, мэдээллийг нийгмийн ажилтан утсан дээрээ код нэрээр хадгалах.
 - 2. Үйлчлүүлэгчийг бусад үйлчилгээнд холбон зуучлах хэрэгтэй болсон үед хувийн мэдээллийг (ж: нэр, утас гэх мэт) тэмдэглэж, зөвхөн тухайн хэрэгцээнд ашиглаад устгах хэрэгтэй.
 - iv. Кейсийн талаар утсаар ярих, мессэж бичих үедээ үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг дурьдахгүй байх ёстой.

4. **Зайнаас тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхи, боломжийг бэхжүүлэх.** Зайнаас цахим хэлбэрээр үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг боловсруулж, түгээх. Зайнаас тусламж үйлчилгээ үзүүлэх, аливаа шинэ техник технологи ашиглахад ажилтнуудыг яаралтай сургаж, бэлтгэх. Энэ хүрээнд ажилтнуудад сэтгэцийн эрүүл мэндийн тайван байдлаа хадгалах, зохицуулах, ажил үүргээ тайван, итгэлтэй байдлаар гүйцэтгэхэд туслах зорилгоор шаардлагатай нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээг багтаасан сэтгэцийн эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх ажил багтана.

5. **Хөл хорионы үед үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад төрлийн үйлчилгээнд шилжүүлэх ажлыг урьдчилж боловсруулж, төлөвлөнө.** Ингэхдээ дараах асуудлуудыг анхаарна:

- a. НЦҮТ-д хөл хорио тогтоосон эсвэл үйлчлүүлэгч ихтэй хүчин чадал нь хүрэлцэхгүй болсон тохиолдолд нэмэлт байр гаргах ажлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран зохицуулах. Нэмэлт байгууламжинд ямар үйлчилгээг, хэрхэн үзүүлэх тухай мэдээллийг үйлчлүүлэгчдэд өгөх.
- б. НЦҮТ/ТХБ үйлчлүүлэгч ихтэй, хүчин чадал нь дээд цэгтээ хүрсэн тохиолдолд үйлчлүүлэгчдийг хамгийн ойр байрлах бусад аймаг, дүүргийн НЦҮТ/ТХБ-луу шилжүүлэх боломжийг судалж, зохицуулах. Үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангаж, тээвэрлэх хувилбаруудыг хэлэлцэх.
- в. НЦҮТ-ийн ажилтан, үйлчлүүлэгч Ковид-19 цар тахлын хавьтагч болсон тохиолдолд авах арга хэмжээг орон нутгийн эмнэлэг, эрүүл мэндийн бусад байгууллагатай хамтарч зохицуулах.

- г. Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотойгоор үйлчилгээний хүртээмж өөрчлөгдөхөөр бол сар бүр холбон зуучлах зураглалыг /referral pathways/ шинэчилж байх хэрэгтэй. Ингэхдээ дараах асуултуудыг харгалзаж үзнэ. Үүнд:
- i. Ямар байгууллагууд үйлчилгээгээ үргэлжлүүлэн хүргэсээр байна вэ? Хэрхэн холбон зуучилж ямар төрлийн үйлчилгээ авах боломжтой вэ?
 - ii. Үйлчилгээг биеээр үзүүлж байна уу эсвэл зайнаас юмуу утсаар үзүүлж байна уу?
 - iii. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үйлчилгээ үзүүлэхэд ямар нэг хязгаарлалт байна уу? Үүнд үйлчилгээ үзүүлэх цагт орсон өөрчлөлт, ажилчдын тоо багассан эсэх, үйлчилгээг саадгүй авах боломж байгаа эсэх, үйлчилгээ авахын тулд нийтийн тээврээр зорчих хэрэгтэй эсэх, үйлчилгээг зайнаас үзүүлэх боломжтой эсэх, Ковид-19 цар тахлын халдвар авах эрсдэлтэй эсэх, мөн ПСР шинжилгээний сөрөг хариу зэрэг ковид 19-тэй холбоотой бусад нэмэлт шаардлагууд орж болно.

6. Болзошгүй өөрчлөлтийн талаар холбогдох талуудад мэдэгдэх.

- а. Үйлчлүүлэгчдийг шаардлагатай бусад үйлчилгээнд шилжүүлэх, тэдэнд үзүүлэх үйлчилгээнд гарсан аливаа өөрчлөлтийг өөрсдөд нь мэдэгдэх. Ямар үйлчилгээг хэрхэн авах тухай мэдээллийг үйлчлүүлэгчдэд өгөх. Үйлчлүүлэгчдэд нөлөөлөх аливаа өөрчлөлт, төлөвлөгөөг тэдэнд танилцуулж, саналыг нь авах, өөрсдөд нь хамгийн тохиромжтой хувилбарыг сонгох боломжийг тэдэнд олгох.
- б. Бусад үйлчилгээ үзүүлэгч нартай хамтран ажиллаж, үйлчилгээний уялдаа холбоог хангаж, зохицуулах. Ингэхдээ хамгаалах байрны аюулгүй, хүртээмжтэй байдлыг хангаж, хууль сахиулах албатай үйл ажиллагаагаа уялдуулах.
- в. Үйлчлүүлсэн хүмүүс, хүчирхийлэлд өртөн нуугдаж буй хүмүүс цаашид НЦҮТ-өөр үйлчлүүлэхийн тулд юу хийх шаардлагатай, үйлчилгээнд ямар өөрчлөлт орсон тухай тэдэнд мэдээлэх.
- г. Хүчирхийллийн тохиолдлуудыг шийдвэрлэх үйл ажиллагаа, санхүүжилтын хэрэгцээ өөрчлөгдөж, тахалаас үүдэлтэй онцгой байдалд бэлтгэж байгаа тохиолдолд энэ талаар хандивлагчдад нэн даруй мэдээлэх. Хөрөнгө нөөцийн захиран зарцуулалтыг уян хатан болгож, шаардлагатай эд зүйлсийг нэн даруй худалдан авах хялбаршуулсан механизмаар ажиллах хүсэлт тавих.
- д. Танай болон холбогдох талуудын хувьд ямар шугамаар мэдээлэл өгөх нь тохиромжтойг тодорхойлох. Олон нийт, ард иргэдэд тусламж хэрэгтэй болсон үед хаанаас хэрхэн үйлчилгээ авах талаар маш тодорхой, ойлгомжтой мэдээллийг хүргэх. Ингэхдээ НЦҮТ/ТХБ-ны аюулгүй байдал, нууцлалыг илчлэхгүйгээр мэдээллийг хүргэх тал дээр анхааралтай ажиллах.

Г. ХҮЧИРХИЙЛЛИЙН ТОХИОЛДЛУУДЫГ ЗАЙНААС ШИЙДВЭРЛЭХ АРГА ХЭЛБЭРҮҮД⁵

Хөл хорио тогтоож, хүмүүсийн хөдөлгөөн, харилцааг хязгаарласан үед халдвараас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээ авч, үйлчлүүлэгчидтэй биеэр уулзан тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжтой. Үүний тулд эрүүл мэндийн байгууллага дээр

нийгмийн ажилтнуудыг байршуулж, доорх хэлбэрээр ажиллаж болно. Хүмүүсийн хөдөлгөөнийг хатуу хориглосноос үүдэн үйлчилгээ үзүүлэхэд цаг алдах тохиолдолд хүчирхийллийн тохиолдлуудыг зайнаас шийдвэрлэх дараах хувилбаруудыг ашиглаж болно. Эдгээр хувилбаруудыг хамтарсан багийн гишүүдтэй ярилцаж, өөрсдийн нөөц, чадавхид нийцсэн хувилбарыг тодорхойлно уу.

1. Эрүүл мэндийн байгууллага дээр нийгмийн ажилтан байршуулах. Хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлаж, эрүүл мэндийн тогтолцоонд тусламж, үйл ажиллагаа төвлөрсөн үед нийгмийн ажилтанг эрүүл мэндийн байгууллага дээр байршуулах, мөн шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэлээр хангах нь оновчтой. Ингэснээр корона вирусийн халдвар авсан охид, эмэгтэйчүүд болон хүчирхийлэлд өртөж, эмнэлэгт хандсан хүмүүст нийгмийн ажилтан тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой болно. Энэ загварыг Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад эболагийн тархалтын эсрэг хариу арга хэмжээ авахад ашигласан юм. Халдвараас сэргийлж, аюулгүй тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд эрүүл мэндийн багтай нягт хамтран ажиллах шаардлагатай. Нийгмийн ажилтнууд эмнэлэг дээр эмнэлгийн ажилтнуудад нэмэлт ачаалал учруулахгүй байхад анхаарч, ЖСХ-ийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн амь насыг хамгаалах зорилготойг ойлгуулж, харилцан ойлголцох нь чухал.

2. Хүчирхийлэлд өртөгчдөд гар утсаар үйлчилгээ үзүүлэх (утсаар болон тусламжийн утсаар зөвлөгөө өгөх удирдамжийг үзнэ үү). Нийгмийн ажилтнууд гар утсаар ашиглан хүчирхийлэлд өртөгчдөд тусламж үзүүлэх боломжтой. Ингэхдээ дараах асуудлуудад анхаарна. Үүнд:

- а.** Тусламж үйлчилгээ үзүүлэхэд нь зориулж нийгмийн ажилтанд тусад нь гар утасны сим карт юмуу эсвэл гар утас авч өгөх.
- б.** Цахилгааны эх үүсвэр: Нийгмийн ажилтнууд цахилгаан, эрчим хүчний ямар эх үүсвэр ашиглаж байна? Гар утсаа байнга цэнэгтэй байлгахад тэдэнд бэрхшээл учирч байна уу? Тэднийг нэмэлт баттерей юмуу эсвэл нарны эрчим хүчээр ажилладаг цэнэглэгчээр хангах боломжтой юу?
- в.** Бусад ажилтнууд, эсвэл үйлчлүүлэгчидрүү утсаар ярих, тэднээс дуудлага хүлээж авах аюулгүй орчныг бүрдүүлэх. Ингэж ажиллахад тэдний яриаг хэн нэгэн сонсох, эсвэл нууцлалыг хадгалах журам зөрчигдөх эрсдэлтэйг анхаарах.
 - i.** Нийгмийн ажилтан гар утас, компьютерээ өөрийн гэр бүлийн бусад гишүүдтэй хуваалцдаг уу? Тэдэнд гадагшаа дуудлага хийх болон дуудлага хүлээн авахдаа хэн нэгэн сонсохгүй байх тусгай/хувийн өрөө байгаа юу? Эдгээр эрсдлүүдийг шийдвэрлэх арга зүйн болон санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх хэрэгтэй болох магадлалтай.
 - ii.** Үйлчлүүлэгч гэр бүлийн гишүүдтэйгээ нэг утас дундаа хэрэглэдэг үү? Тэд хүчирхийлэл үйлдэгчтэй хамт нэг дор, хязгаарлагдмал орон зайд тусгаарлалтанд байгаа юу? Хэрэв тийм бол нийгмийн ажилтан үйлчлүүлэгчтэй ярихдаа код ашиглаж ярих эсвэл холбогдох өөр арга замыг эрэлхийлэх хэрэгтэй болно.

г. Мэдээллийг хэрхэн цуглуулах вэ? Нийгмийн ажилтнууд гэртээ юм уу эсвэл аюулгүй байдлыг хангаагүй газар баримт бичиг хадгалахаас зайлсхийх. Хүчирхийллийн тохиолдлуудын мэдээ, баримтуудыг хадгалах Primo/GBVIMS+ зэрэг цахим хэрэгслүүдийг ашиглах.

3. **Тусламжийн утсаар (hotline) зөвлөгөө өгөх үйлчилгээ (утсаар болон тусламжийн утсаар зөвлөгөө өгөх удирдамжийг үзнэ үү).** Утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ байдаг бол уг үйлчилгээг 24 цагаар ажиллуулах зохион байгуулалтыг хийж, зөвлөгөө өгөх ажилтнуудыг бэлтгэх, шаардлагатай мэдээлэл, холбон зуучлах байгууллагуудын утас хаягаар хангах. Энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг 102, 107, 108 болон Гэмтлийн эмнэлэг дээрх НЦҮТ /70180139/, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн хамгаалах байрны 96490505 утсанд холбогдож тусламж авах. Мөн эдгээр үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн тусламж, үйлчилгээтэй уялдуулж, уг утсаар дамжуулан нийгмийн ажилтнуудын утасны дугаарыг мэдээлэх боломжийг судлах. Дуудлагын утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээ байдаггүй бол гар утас шинээр авч, нийгмийн ажилтнуудыг ээлжээр ажиллуулан, уг утсаар зөвлөгөө өгдөг болгох. Нийгмийн ажилтнууд өөрсдөө хөл хорионд орсон тохиолдолд тэд бас гэртээ хариуцлага хүлээж, өөрсдийн асуудалд стресстэй байдгийг анхаарна уу. Иймд, ямар тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой, аюулгүй найдвартай болохыг тэдэнтэй ярилцах нь чухал.

4. **Мессэжээр харилцах.** Нийгмийн ажилтан, хүчирхийлэлд өртөгчийн хэн хэнд нь мессэжээр харьцах нь илүү тохиромжтой байж болох юм. WhatsApp, Viber, эсвэл Telegram болон өөр бусад аппликейшнуудыг ашиглаж мессэжээр харьцах боломжтой. Ингэхдээ үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын стресс, ар гэртээ хүлээсэн үүрэг хариуцлага, аюулгүй байдал, цахилгаан эрчим хүч, интернэтийн хүртээмжийг харгалзан үзэх хэрэгтэй.

5. **Хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах цөөн хүнтэй шуурхай/явуулын баг ажиллуулах.** УОК-оос авч буй халдвараас хамгаалах, хянах арга хэмжээний хүрээнд халдвар тархалтын үед нэг дор ажиллах үйлчилгээ үзүүлэгчдийн тоог хязгаарлаж, шуурхай баг ажиллуулж болно. Энэ тохиолдолд учирсан эсвэл учирч болзошгүй эрсдлийг үнэлж, үр ашиг нь давамгайлж байвал нийгмийн ажилтныг уг багт оруулахын төлөө ухуулга нөлөөлөл хийх.

Д. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД БАЙРЛАЖ БУЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРСЭН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ⁶

1. **Ковид-19 цар тахлын шинж тэмдгүүдийн (тухайлбал: ханиах, халуурах, амьсгаа давхцах) аль нэг нь юмуу хэд хэдэн шинж тэмдэг илэрсэн эсвэл Ковид-19 цар тахлын халдвартай хүнтэй хавьтсан үйлчлүүлэгчийг нэн даруй тусгаарлах өрөө рүү шилжүүлнэ.** Хамт явж буй хүүхдүүдийг нь мөн адил тусгаарлана. Ковид-19 цар тахлын халдвар авсан байж болзошгүй шинж тэмдэг илэрсэн тохиолдолд Засгийн газрын удирдамжийн дагуу тэднийг холбогдох эрүүл мэндийн засаг захиргааны байгууллагад мэдэгдэх ёстой гэдгийг үйлчлүүлэгчдэд тайлбарлах.

2. Эрүүл мэндийн байгууллагатай холбогдож, үйлчлүүлэгчийн шинж тэмдэг, ойрын хавьтал, эрсдэлт хүчин зүйлс (тухайлбал, нас, эрүүл мэндийн байдал) зэргийг мэдээлж, ямар арга хэмжээ авах талаар зөвлөгөө авах. Боломжтой бол эрүүл мэндийн ажилтнуудад тухайн үйлчлүүлэгчийн шинж тэмдэг, мөн хаагуур явж, хэнтэй уулзсан тухай мэдээллийг өгснөөр хавьтагчийг тодруулах ажилд дэмжлэг үзүүлнэ.
3. Эрүүл мэндийн байгууллагаас тухайн үйлчлүүлэгчийг НЦҮТ-д тусгаарлахыг зөвлөсөн тохиолдолд:
- а. Тухайн үйлчлүүлэгч, дагуулж яваа хүүхдүүдийнхээ хамт тусдаа өрөөнд 14 болон түүнээс дээш хоног тусгаарлагдах шаардлагатайг тайлбарлах. Тусгаарласан үед тэднийг зохих үйлчилгээ түүний дотор хоол хүнс, өдөр тутмын хэрэгцээний зүйлс, цагийг зугаатай өнгөрөөх эд зүйлсээр хангах.
 - б. Аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд гар утсаар зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх дүрэмтэй гэдгийг тайлбарлах. Нийгэм, сэтгэл зүйн зөвлөх, бусад үйлчилгээ үзүүлэгчид түүнтэй гар утсаар нь холбогдож, үйлчилнэ. Мөн үйлчлүүлэгч хамгаалалтад байхын сацуу эмнэлэгт эрүүл мэндийн тусламж авах боломжтой гэдгийг үйлчлүүлэгчдэд тайлбарлаж мэдэгдэх.
 - в. Ижил төстэй шинж тэмдэг илэрч буй үйлчлүүлэгчдийг шаардлагатай үед нэг өрөөнд хамтад нь тусгаарлаж болно. Ингэхдээ тэднийг бие биенээсээ дор хаяж 1 метрийн зайтай байлгаж, халдвараас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
4. Эрүүл мэндийн байгууллагаас тухайн үйлчлүүлэгчийг эмнэлэгт хүргэхийг зөвлөсөн тохиолдолд:
- а. Үйлчлүүлэгчийг дагуулж яваа хүүхдүүдийнх нь хамт эмнэлэгт аюулгүй хүргэж өгөх тээвэрлэлтийг зохицуулах. Үйлчлүүлэгч нь ЖСХ-ийн хохирогч тул мэдрэмжтэй харьцаж, хамгаалалтад байлгах шаардлагатайг тухайн эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх.
 - б. Үйлчлүүлэгчийн бие сайжирч байгаа эсэхийг НЦҮТ-д тогтмол мэдээлж, эмнэлгээс гарахад нь НЦҮТ-д авч ирэх ёстой гэдгийг тухайн эмнэлэгт мэдэгдэх.
 - в. Нөхцөл байдлыг үйлчлүүлэгчдэд тайлбарлаж, бүх үйл явцад ил тод байдлыг хангах. Үйл явцын талаар асууж, лавлах боломжийг үйлчлүүлэгчдэд олгож, засгийн газрын эрүүл мэндийн зөвлөмж, баталгаатай бусад эх сурвалжид тулгуурлан тодорхой мэдээлэл өгөх. Асуултанд нь хариулж мэдэхгүй бол тааж хариулж болохгүй. Харин холбогдох хүмүүсээс асууж лавлаад, хариу өгөх.
5. НЦҮТ-д байрлаж байгаа бусад бүх үйлчлүүлэгчдийн дунд ил тод байдлыг хангах. Нөхцөл байдлын талаар баримтад тулгуурлан тайван тайлбарлах, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй зөвлөж, бүх шийдвэрийг гаргаж байгааг үйлчлүүлэгчдэд мэдэгдэх. Тэнд байрлаж буй хүмүүсийг халдвараас сэргийлэх зорилгоор авч буй бүх арга хэмжээг тайлбарлаж, мэдээлэх. Халдварын ямар нэг шинж тэмдэг илэрвэл НЦҮТ/ТХБ-ны ажилтанд мэдэгдэх хэрэгтэй гэдгийг үйлчлүүлэгчдэд тайлбарлаж, халдварын шинж тэмдэг илэрсэн хүмүүст хамгаалалт, үйлчилгээг өөр арга, хувилбаруудаар үргэлжлүүлэн үзүүлнэ гэдгийг ойлгуулах.

Е. АЖИЛТНУУДЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ

Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах нь аливаа үйл ажиллагааны үндэс юм. Хэрэв ажилтнууд, үүрэг хүлээсэн хүмүүс цар тахлаас үүдэн стресс бухимдалтай байвал тусламж хэрэгтэй зорилтот үйлчлүүлэгчдэд үр дүнтэй үйлчилгээ үзүүлэх боломжгүй болно. Иймд халдварын тархалт нэмэгдсээр байгаа үед ажилтнуудад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх тогтолцоог бий болгох шаардлагатай.

1. Ажилчиддаа санаа тавих ажлыг нэн тэргүүнд авч үзэх⁷

- a.** Ажилтнуудын санаа зовоож буй асуудал, хэрэгцээ, цаашид юу хийх шаардлагатай тухай тэдний санаа бодлыг сонсох боломжийг бүрдүүлэх. Хэрвээ үйлчилгээ үзүүлж байгаа ажилтнууд болон үүрэг хүлээсэн хүмүүс Ковид-19 цар тахлын улмаас стресс ихтэй, айдастай байвал үйлчилгээ авахаар ирсэн хүмүүст шаардлагатай үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх боломжгүй гэдгийг анхаарч, ажил эсвэл ерөнхий нөхцөл байдлын талаар ажилтнууд чөлөөтэй ярих цаг гаргах нь зүйтэй. Халдвар тархалтын бүх үе шатанд үүнийг цахим уулзалт эсвэл биечлэн уулзах хэлбэрээр зохион байгуулах.
- b.** Халдвараас хамгаалах, хянах арга хэмжээг хэрэгжүүлэх; эрсдлийг бууруулах ажил хийх.
- c.** Стрессээ багасгах, сэтгэл санаагаа тайван тогтвортой байлгах арга, хэрэгслээр хангах. Үүнд: сэтгэцийн эрүүл мэндийн холбогдолтой мэдээллийн материал боловсруулах, түгээх, өөрийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тогтвортой байлгахад туслах энгийн дасгалуудыг танилцуулах, нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг, зөвлөгөөг ажилтнуудад болон утсаар холбогдож байгаа хүмүүст өгөх гэх мэт багтана. Тухайлбал, энгийн дасгал хөдөлгөөн хийх мэдээллийг өдөр бүр мессэжээр юм уу эсвэл WhatsApp группээр түгээх, сэтгэл зүйн дэмжлэг зөвлөгөө авах утасны дугаарыг түгээх гэх мэт.
- d.** Ажилтнуудад үзүүлэх дэмжлэгт үйлчилгээний талаарх мэдээлэл, утасны дугаарыг бүх ажилтнуудад өгөх.
- e.** Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж ажилтнуудтайгаа утсаар юмуу эсвэл WhatsApp-аар байнга холбогдох. Ажилтнууд бие биетэйгээ холбогдож, дэмжлэг үзүүлэх групп чат юмуу эсвэл өөр бусад группыг үүсгэх.
- f.** Ажилтнуудад ур чадвараа сайжруулах боломжийг олгосон мэдээлэл өгөх, онлайн сургалтуудыг зохион байгуулах.

Ё. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕД ЖСХ-ИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХДАА АНХААРАХ ГОЛ АСУУДЛУУД⁸

- 1. Ажилтнууд, үйлчлүүлэгчдийн аюулгүй, сайн сайхан байдлыг эн тэргүүнд анхаарах.** ЖСХ-ийн эсрэг аливаа хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд энэ зарчмыг баримталдаг бөгөөд ковид19-ийн эсрэг хариу арга хэмжээ авахдаа ч энэ зарчмыг мөрдөх.
- 2. Хамгийн эмзэг бүлгийн хүмүүст хүрч ажиллах.** Зарим үйлчлүүлэгч, хүн амын бүлэг бусадтай харьцуулахад илүү эмзэг, аливаа зүйлд илүү өртөмтгий байдаг. Иймд олон хүн цугласан газраас зайлсхийх, бусадтай зайнаас харьцах нь үйлчлүүлэгчдийг

төдийгүй бусдын төлөө ажиллаж буй бүх хүнийг эрсдэлээс хамгаална. Шийдвэр гаргахдаа үүнийг санаж, нэн ялангуяа эмзэг бүлгийн үйлчлүүлэгчдийг анхаарч, тэдний нөхцөл байдлыг өөрчлөх, шат дараалсан арга хэмжээнүүдийг тогтмол авах хэрэгтэй.

- 3. Бүтээмжээс илүү хүнлэг байхад анхаарах.** Энэ бол стресстэй цаг үе. Тодорхойгүй байдал, гэнэтийн өөрчлөлт нь ажилтнууд болон тэдний гэр бүл, үйлчлүүлэгчид, олон нийтийг улам их стрессдүүлдэг. Хөтөлбөрт өөрчлөлт оруулахдаа шилжилтийг алгуурлаж, бүтээмжтэй ажиллахад хэт их анхаарах хэрэггүй. Шилжилтийн хурдыг сааруулж, цаашид юу болохыг төсөөлж, ажлаа үргэлжлүүлэхийн сацуу стрессээ тайлахад ажилтнуудад цаг хугацаа хэрэгтэй. Иймд бүх хүнд амьсгаа авч, амсхийхэд нь тусалж, энэ нөхцөл байдлыг байж болох зүйл гэдгийг ойлгуул.
- 4. Цочирдолд оролгүй, бэлтгэлээ хангах.** Гарч болох бүх эрсдлийг тооцож, гэнэтийн өөрчлөлтүүдэд бэлтгэх. Өөрчлөлтийг аль болох уужуу тайван төлөвлөж, бусдыг цочирдуулалгүй, идэвхитэй арга хэмжээ авч энгийн хэлбэрээр танилцуулж, хэрэгжүүлэх.
- 5. Хариу арга хэмжээнүүдэд жендэрийн дүн шинжилгээ хийхийг дэмжих.** Энэхүү удирдамж нь ЖСХ-ийн тохиолдлуудыг шийдвэрлэхэд голлон анхаарна. Бүх хүмүүс ялангуяа охид, эмэгтэйчүүдэд чиглэсэн зөв зохистой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд жендэрийн дүн шинжилгээ чухал ач холбогдолтой. Бүс нутагтаа илүү жендэрийн мэдрэмжтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд холбогдох салбаруудад ухуулга нөлөөлөл хийж, удирдамжаар хангах хэрэгтэй.

Ж. ЖСХ-ИЙН ХОХИРОГЧИДТОЙ АЖИЛЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ⁹

ЖСХ-ийн хохирогчидтой ажиллахдаа хохирогчийн эрх, хүсэл сонирхолыг нь хүндэтгэж, аюулгүй байдлыг хангаж, тэдэнтэй хүнлэг, хүндэтгэлтэй харьцдаг дэмжлэгт орчинг бүрдүүлэх нь маш чухал. Ялангуяа Ковид-19 цар тахал зэрэг хямралын үед энэ нь онцгой ач холбогдолтой бөгөөд дараах зарчмуудыг байнга дагаж мөрдөх шаардлагатай:

- 1. Аюулгүй байдал.** Хохирогч, түүний хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангахад онцгойлон анхаарах.
- 2. Нууцлалыг хангах.** Хохирогч асуудлаа хэнд ярих, ярихгүйгээ шийдэх эрхтэй. Хохирогчийн тухай мэдээлэл, түүний ярьсан зүйлийг өөрөөс нь зөвшөөрөл авч, бусдад мэдээлнэ.
- 3. Хүндэтгэх.** Бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хохирогчийн сонголт, хүсэл, эрх, нэр төрийг хүндэтгэнэ. Тусламж, үйлчилгээ үзүүлж буй ажилтнууд хохирогчдыг хэвийн байдалд эргэж ороход нь тусалж, дэмжих үүрэгтэй.
- 4. Ялгаварлахгүй байх.** Нас, хүйс, арьсны өнгө, шашин шүтлэг, яс, үндэс, бэлгийн чиг хандлага, бусад онцлогийг үл харгалзан хохирогчидтой тэгш, шударга харьцах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД:

Энэхүү удирдамжийг олон улсын хэмжээнд туршигдсан дараах удирдамжуудыг Монгол орны нөхцөл байдалд тохируулан боловсруулсан болно.

- ▶ ^{1,3,5,7,8} “ЖСХ-ийн кэйс менежмент ба КОВИД-19 цар тахал” удирдамж; Робин Яакер, Доргас Эркин (2020), Дэлхийн ЖСХ-ийн баг
- ▶ ^{2,6} “Ковид-19 цар тахлын үеэр бүрэн хөл хорио тогтоосон нөхцөлд үйл ажиллагаа явуулах түр хамгаалах байрны үйлчилгээний протокол” Паро Чаужар (2020), Непалийн Үндэсний Эмэгтэйчүүдийн Зөвлөлийн захиалгаар Дэлхийн банкны санхүүжилтээр боловсруулав.
- ▶ ⁴ “Ковид-19 цар тахлын үед гар утас болон дуудлагын утсаар зайнаас үйлчилгээ үзүүлэх удирдамж”, Дэлхийн ЖСХ-ийн баг, Олон улсын эрүүл мэндийн корпус, Олон улсын аврах хороо, Норвегийн олон улсын сүмийн тусламжийн байгууллага, План олон улсын байгууллага, Трокейр, НҮБХАС, НҮБ-ын Дүрвэгсдийн Асуудал Эрхэлсэн Дээд Комиссарын Газар, НҮБ-ын Хүүхдийн сан
- ▶ ⁹ “Онцгой байдлын үеийн Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” НҮБХАС.

ХАМГААЛАХ БАЙРНЫ АРИУН ЦЭВЭР ХАЛДВАРГҮЙЖИЛТИЙН БАЙДЛЫГ ШАЛГАХ АСУУМЖ¹

<input type="checkbox"/>	Гадаргууг тогтмол халдваргүйжүүлэх. Өдөр бүр цэвэрлэж, ариутгах зүйлс: Нийтийн байр, талбай, өрөөнүүдийн хаалганы бариул, усны цорго, крант, гар нүүрийн угаалтуур, телефон утас, лангуу, ширээ, сандал, буйдан, гал тогоо, хоол идэх газар, аяга таваг зэрэг янз бүрийн хүмүүсийн гар хүрдэг эд зүйлс. Мөн ор, үйлчлүүлэгчдийн ачаа хадгалах хайрцаг сав зэрэг үйлчлүүлэгчдийн байр талбайг цэвэрлэж, ариутгах. Цэвэрлэгээ, ариутгалын бодисыг хэрэглэх зааврыг уншиж, зөв зохистой хэрэглэх. Халдварт өвчин гарсан тохиолдолд өдөрт цэвэрлэгээ хийх давтамжийг нэмэгдүүлэх, ялангуяа халдвартай хүмүүсийн байрлаж байгаа газрыг байнга цэвэрлэх.
<input type="checkbox"/>	Эрүүл ахуйн анхааруулга заавруудыг байршуулах (амаа таглаж ханиах, гараа угаах) заавруудыг зохих хэлээр бичиж, шаардлагатай газруудад байршуулах.
<input type="checkbox"/>	Хамгаалах байрны шал, гадаад орчинг шүүрдэж, халдваргүйжүүлэх, хог хаяхгүй байх.
<input type="checkbox"/>	Дундын байр талбай, унтлагын өрөөнүүдийг үргэлж цэвэрлэж, эмх цэгцтэй байлгах.
<input type="checkbox"/>	Хогийн савыг дүүрэнгүүт, хогийг нь гаргаж хаях. Эмнэлгийн хог хаягдлыг ердийн хог хаягдалтай холихгүй байх, хог хаях газруудыг аюулгүй цэвэрхэн байлгаж, хортон мэрэгч, шавьжийг устгах. Тариурын зүү болон бохирдсон өөр бусад хурц үзүүртэй зүйлсийг зүү нэвтэрдэггүй саванд хаях. Эмнэлгийн хог хаягдлыг хаях, устгах зааврыг мэдэхгүй бол эрүүл мэндийн газартай холбогдож, лавлах.
<input type="checkbox"/>	Хувийн ариун цэврийг сахиx: Хамгаалах байранд үйлчлүүлэгчид усанд орж, хувцасаа угааж, бие засах газраа байнга цэвэрхэн байлгах.
<input type="checkbox"/>	Цагаан хэрэглэл, бохир хувцаснуудыг зохих газар хадгалж, угаах. Бохирдсон хувцас хэрэгсэлийг биедээ ойр байлгахаас зайлсхийх. Шаардлагатай үед цайруулагч блезна ашиглах.
<input type="checkbox"/>	Халдварт өвчний шинж тэмдэг үйлчлүүлэгч нарт илэрч байгаа эсэхийг ажиглах. Шинж тэмдэг илэрч байгаа хүмүүсийг шинжилгээнд хамруулах, хамгаалах байрны журмын дагуу зохих хүмүүст мэдэгдэж, шилжүүлэх.
<input type="checkbox"/>	Хамгаалах байрны хаана ямар хүн байрлаж, үйлчлүүлсэнийг өдөр тутам тэмдэглэж, халдвар тархсан тохиолдолд хамгийн ойрын хавьталттай, халдвар авах хамгийн их эрсдэлтэй хүмүүсийг тодорхойлох боломжтой байх.
<input type="checkbox"/>	Бохирдол, халдвар тархахаас сэргийлэх: үйлчлүүлэгчдийн эд зүйлсийг хооронд нь хольж хутгахгүй, ойртуулахгүй, тус тусад нь хадгалах.
<input type="checkbox"/>	Дараах зүйлсийг хангалттай авч, нөөцлөх. Үүнд: анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай эм, эд зүйлс бүхий явуулын эмийн сан, цэвэрлэгээний материал, хувийн ариун цэврийг хангахад шаардлагатай зүйлс (микробын эсрэг саван, гар арчих цаас, 00-ийн цаас гэх мэт), хамгааллын хувцас, хэрэгсэл.
<input type="checkbox"/>	Ээлж солигдоход мэдээлэл солилцох журамтай болох: Ээлжийн ажилтнууд ажлаа хүлээлцэж, мэдээлэл солилцох дэвтэр ажиллуулах, компьютерт мэдээллээ оруулж, солилцох, эсвэл өөр бусад аргаар ээлжүүд хоорондоо мэдээлэл солилцдог болох. Менежерүүд энэ журмыг мөрдлөг болгож хэрэгжүүлэх.
<input type="checkbox"/>	Саван, гар арчих цаас бүхий угаалтууруудыг хэд хэдэн газар байршуулах: Үүд, хамгаалах байр болон хүмүүс цугладаг газар байршуулах.
<input type="checkbox"/>	Гар ариутгагчийг хангалттай нөөцөлж, үүд болон хамгаалах байр зэрэг хэд хэдэн газар байршуулах.
<input type="checkbox"/>	Орнуудыг дор хаяж 1 метрийн зайтай байрлуулах. Том өрөөнүүдэд орнуудын хооронд хөшиг татаж, тусгаарлах.
<input type="checkbox"/>	Халдвартай хүмүүст зориулж дараах зүйлсийг нөөцлөх. Үүнд: өвчтэй хүмүүсийн орны хажууд гар ариутгагч, салфетка цаас, хогийн сав, уут байрлуулах.
<input type="checkbox"/>	Шаардлагатай тохиолдолд хүмүүсийг тусгаарлах төлөвлөгөө боловсруулах. Оновчтой хувилбаруудыг олохын тулд хамгаалах байрны ажилтнууд эмнэлэг, эрүүл мэндийн ажилтнуудтай зөвлөх боломжтой байх.
<input type="checkbox"/>	Өрөөг агааржуулах: өрөөний температурыг тогтвортой байлгаж, агаар солилцоог сайжруулах.

¹ Энэхүү шалгах асуумжийг “Халварт өвчний үед тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах арга зүй: Хамгаалах байранд халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх нь” удирдамжаас Монгол орны нөхцөлд тохируулан боловсруулав. АНУ-ын Орон сууц, хот тохижилтийн газар (2020)